



2017 оны 03 дугаар сарын 02  
№ 09 /966/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Монгол Улсын  
хууль

390

**Дипломат албаны тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын  
хууль

402

**Монгол Улсын Хөгжлийн  
банкны тухай  
/Шинэчилсэн найруулга/**

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

422

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

168.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	386
169.	Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	390
170.	Зөвлөлдөх санал асуулгын тухай	391
171.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	400
172.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	401
173.	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	401
174.	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	402
175.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга/	402
176.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	417
177.	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	417
178.	Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	418

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

179.	Нийтийн сонсгол зохион байгуулах журам батлах тухай	Дугаар 12	418
------	---	-----------	-----

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

180.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 10	422
------	--	-----------	-----



181.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 11	423
182.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 12	423
183.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 13	424

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай Наймдугаар бүлэг нэмсүгэй:

#### “НАЙМДУГААР БҮЛЭГ НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

**51<sup>1</sup> дүгээр зүйл.** Нийтийн сонсгол

51<sup>1.1</sup>. Нийтийн сонсголын тухай хуульд заасан Улсын Их Хурлаас зохион байгуулах хууль тогтоомжийн төслийн, ерөнхий хяналтын, томилгооны сонсголыг холбогдох Байнгын болон дэд, түр хороо, төсвийн хяналтын сонсголыг Төсвийн байнгын хороо зохион байгуулна.

51<sup>1.2</sup>. Нийтийн сонсголыг нэгдсэн болон тухайн Байнгын, дэд, түр хорооны хуралдаантай давхардуулахгүйгээр зохион байгуулах бөгөөд Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт зохион байгуулж болно.

51<sup>1.3</sup>. Нийтийн сонсгол зохион байгуулах хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд түүнд сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх ба сэдэв, зорилго, товчн талаархи саналаа тусгаж болно.

51<sup>1.4</sup>. Иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомжийн төслийн, ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэн бол холбогдох Байнгын болон дэд, түр хороо Нийтийн сонсголын тухай хуулийн 7.1, 8.4-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тухайн асуудлаар нийтийн сонсгол явуулах эсэхийг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв нийтийн сонсгол зохион

байгуулах шаардлагагүй гэж үзсэн бол үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын гурван өдрийн дотор бичгээр өгнө.

51<sup>1.5</sup>.Хууль тогтоомжийн төслийн сонсгол зохион байгуулахыг Нийтийн сонсголын тухай хуулийн 7.2-т зааснаар холбогдох Байнгын хорооны нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар шийдвэрлэнэ.

### **51<sup>2</sup> дугаар зүйл.Нийтийн сонсголын бэлтгэл хангах**

51<sup>2.1</sup>.Холбогдох Байнгын болон дэд, түр хорооноос нийтийн сонсголын товыг тогтоосон бол товлосон өдрөөс хойш долоо хоногийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Улсын Их Хурлын цахим хуудсаар сонсгол явуулах сэдэв, огноо, цаг, байр, ажиглагчаар оролцох хүний тоо, оролцогчдыг хэрхэн бүртгэх, бүртгэл дуусах хугацааг нийтэд зарлаж мэдээлнэ.

51<sup>2.2</sup>.Нийтийн сонсголын товыг хойшлуулах шаардлагатай бол Нийтийн сонсголын тухай хуулийн 20.4-д зааснаар дахин зарлана.

51<sup>2.3</sup>.Тодорхой асуудлаар санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч /цаашид “оролцогч” гэх/ нар нийтийн сонсгол болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө Байнгын болон дэд, түр хороонд бүртгүүлэх ба бүртгэл дуусмагц тэдний нэрсийг жагсаалтаар гарган Улсын Их Хурлын цахим хуудсанд байрлуулна.

51<sup>2.4</sup>.Оролцогч санал, тайлбар, мэдээллээ нийтийн сонсгол болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө бичгээр өгнө.

51<sup>2.5</sup>.Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах хугацааг товлон зарламагц тухайн асуудлаар дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагад холбогдох баримт бичгийг хүргүүлэх бөгөөд төрийн аудитын байгууллага гаргасан дүгнэлтээ нийтийн сонсгол болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө ирүүлнэ.

51<sup>2.6</sup>.Томилгооны сонсголд тухайн албан тушаалтныг нэр дэвшүүлсэн, санал болгосон этгээд, нэр дэвшигчийг заавал оролцуулна.

51<sup>2.7</sup>.Нийтийн сонсголын зохион байгуулалтын асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.

### **51<sup>3</sup> дугаар зүйл.Нийтийн сонсголд ажиглагчийг оролцуулах**

51<sup>3.1</sup>.Холбогдох Байнгын болон дэд, түр хорооны хуралдаанаар нийтийн сонсголд ажиглагчаар оролцох хүний тоог урьдчилан тогтооно.



51<sup>3</sup>.2.Нийтийн сонсголд ажиглагчаар оролцох иргэн, хуулийн этгээд Нийтийн сонсголын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан хүсэлтийг бичгээр ирүүлэх бөгөөд тогтоосон хугацаанд бүртгүүлсэн байна.

51<sup>3</sup>.3.Ажиглагч нь нийтийн сонсголын үед асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.

#### **51<sup>4</sup> дүгээр зүйл.Нийтийн сонсгол даргалагчийг томилох**

51<sup>4</sup>.1.Холбогдох Байнгын болон дэд, түр хорооны хуралдаанаар нийтийн сонсгол даргалагч /цаашид «сонсгол даргалагч» гэх/-ийг томилно. Энэ хуулийн 16.5-д заасан ажлын хэсгийн, эсхүл нийтийн сонсголыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч нь сонсгол даргалагч байж болно.

#### **51<sup>5</sup> дугаар зүйл.Нийтийн сонсгол зохион байгуулах журам**

51<sup>5</sup>.1.Нийтийн сонсголыг дараахь журмаар зохион байгуулна:

51<sup>5</sup>.1.1.сонсгол даргалагч нийтийн сонсголын зорилго, оролцогчдын ирц, дэгийг танилцуулах;

51<sup>5</sup>.1.2.сонсгол даргалагч оролцогчийн санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах, асуулт асуух дарааллыг тогтоох;

51<sup>5</sup>.1.3.нийтийн сонсголд дуудаж ирүүлсэн албан тушаалтан нь тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан мөн эсэх талаар тодруулга авах;

51<sup>5</sup>.1.4.оролцогчийн санал, дүгнэлт, тайлбар, мэдээллээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх;

51<sup>5</sup>.1.5.Улсын Их Хурлын гишүүн санал, тайлбар, мэдээлэлтэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа дөрвөн минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа нэг минутаас илүүгүй байх;

51<sup>5</sup>.1.6.оролцогч нь Улсын Их Хурлын гишүүний асуултад хариулах хугацаа дөрвөн минутаас илүүгүй, нэмэлт хариулт өгөх хугацаа нэг минутаас илүүгүй байх.

51<sup>5</sup>.2.Оролцогч нь нийтийн сонсголын үеэр сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй.

51<sup>5</sup>.3.Оролцогч нь Нийтийн сонсголын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд санал хэлэх, тайлбар,



дүгнэлт гаргах, асуултад хариулахдаа бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах, бусдын өмнөөс нь үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг үйлдэл гаргахыг хориглоно.

51<sup>5.4</sup>.Нийтийн сонсголын тухай хуулийн 20.5-д зааснаар албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд ирээгүй нь сонсголыг хойшлуулах үндэслэл болохгүй.

51<sup>5.5</sup>.Сонсгол даргалагч нь Нийтийн сонсголын тухай хуулийн 17.1-д заасан эрх, үүргээс гадна дараахь эрхтэй:

51<sup>5.5.1</sup>.сонсголын дэгийг зөрчсөн, энэ зүйлийн 51<sup>5.3</sup>-т заасан үйлдэл гаргасан оролцогчийн үг хэлэх эрхийг сануулахгүйгээр хасах;

51<sup>5.5.2</sup>.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

51<sup>5.5.3</sup>.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.

51<sup>5.6</sup>.Сонсгол даргалагч нийтийн сонсголоор хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг уншиж танилцуулан сонсголын тэмдэглэлд тусгуулж болно.

### **51<sup>6</sup> дугаар зүйл.Нийтийн сонсголыг хаалттай явуулах**

51<sup>6.1</sup>.Нийтийн сонсголын тухай хуулийн 6.3-т зааснаар хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар зохион байгуулах нийтийн сонсголыг хаалттай явуулна.

51<sup>6.2</sup>.Хаалттай сонсголыг явуулахад энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан нийтлэг журам, хаалттай хуралдааны дэгийг баримтална.”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “Наймдугаар” бүлгийн дугаарыг “Есдүгээр” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 01 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дипломат албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/23<sup>1</sup> дүгээр зүйл:**

“23<sup>1</sup> дүгээр зүйл. Гэр бүлийн гишүүний ажлын байрны баталгаа

23<sup>1.1</sup>. Дипломат төлөөлөгчийн газарт ажиллах ажилтны эхнэр буюу нөхөр нь төрийн албан хаагч бол ажил олгогч түүнд томилолтын хугацаагаар чөлөө олгоно.

23<sup>1.2</sup>. Дипломат төлөөлөгчийн газарт ажиллах томилолтын хугацаа дуусч эх орондоо бүрмөсөн буцаж ирэхэд энэ хуулийн 23<sup>1.1</sup>-д заасан ажил олгогч тухайн ажилтны эхнэр буюу нөхрийг ажлын байраар хангах үүрэгтэй.

23<sup>1.3</sup>. Энэ хуулийн 23<sup>1.1</sup>-д заасан ажил олгогч татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо цөөрсөн, хасагдсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27.2.3, 27.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1-д заасны дагуу зохицуулна.”

**2/4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг:**

“4.6. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан болон гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрснөөс бусад тохиолдолд төрийн болон нутгийн захиргааны бусад байгууллага, түүний нэгж, салбар, төлөөлөгчийн газрыг гадаад улсад байгуулах, төлөөлөгч томилон ажиллуулахыг хориглоно.”

**3/15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг:**

“15.6. Энэ хуулийн 15.5-д заасны дагуу дипломат албанд ажиллуулах журмыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**4/18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт:**

“18.1.5. суугаа орны сургуулийн өмнөх боловсролын сургалт



төлбөртэй бол хүүхдийнх нь сургалтын төлбөрийг тухайн улсын сургалтын зардлын дунджийн 70 хувиар тооцон олгох.”

**2 дугаар зүйл.** Дипломат албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэсний дараа “3 жил тутам” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “тухай хууль” гэсний дараа “тогтоомж” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.1. Монгол Улсаас гадаад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчийг болон олон улсын бусад байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгч нь гадаад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүргийг хавсран гүйцэтгэх тохиолдолд түүнийг Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасны дагуу томилж, эгүүлэн татна.”

**4 дүгээр зүйл.** Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “3 жил байна.” гэснийг “4 жил байна. Тайлбар: Энэ хэсэгт оруулсан өөрчлөлт нь 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Дипломат төлөөлөгчийн газарт томилогдон ажиллаж байгаа дипломат ажилтанд хамаарахгүй.” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

##### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн эрх зүйн хүрээнд зөвлөлдөх санал асуулгыг энэ хуульд заасан асуудлаар зохион байгуулж төрийн үйл хэрэгт зөвлөлдөх арга хэлбэрээр иргэдийн оролцоог хангахад оршино.





## **2 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулгын хууль тогтоомж**

2.1.Зөвлөлдөх санал асуулгын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль<sup>2</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

## **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“зөвлөлдөх санал асуулга” гэж нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар энэ хуулийн 3.1.3-т заасан этгээд шийдвэр гаргахын өмнө болон түүнийг хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа байдлын талаар тохиолдлын зарчмаар түүвэрлэн сонгосон иргэдээс тусгай бэлтгэсэн асуултаар санал авах замаар иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах цогц үйл ажиллагааг;

3.1.2.“бие даасан хөндлөнгийн судалгааны байгууллага” гэж нийтийн санал бодлыг судлах судалгааны арга зүйг эзэмшсэн, энэ хуульд заасны дагуу сонгон шалгаруулсан мэргэжлийн байгууллагыг;

3.1.3.“шийдвэр гаргах эрх бүхий этгээд” гэж хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны байгууллага, хуулиар тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргах нийтийн эрх зүйн бусад этгээд, бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагыг.

## **4 дүгээр зүйл.Зөвлөлдөх санал асуулгын зорилго**

4.1.Зөвлөлдөх санал асуулгыг дараахь үндсэн зорилгоор зохион байгуулна:

4.1.1.нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх;

4.1.2.тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх;

4.1.3.иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

4.1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд заасан төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах.

### **5 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулгын зарчим**

5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийг удирдлага болгон зөвлөлдөх санал асуулгыг дараахь зарчмыг баримтлан явуулна:

- 5.1.1.хууль дээдлэх;
- 5.1.2.иргэний бодитой, шууд оролцоог хангах;
- 5.1.3.иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;
- 5.1.4.олон талт мэдээллээр тэгш хангах;
- 5.1.5.ил тод, нээлттэй байх;
- 5.1.6.хараат бус байх;
- 5.1.7.харилцан зөвлөлдөх;
- 5.1.8.үр нөлөөтэй байх.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан зарчмыг зөрчиж зөвлөлдөх санал асуулгын үр дүнд нөлөөлөх, санал асуулгын дүнг санаатайгаар гуйвуулахыг хориглоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГА, ТҮҮНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

### **6 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулга**

6.1.Зөвлөлдөх санал асуулгыг дараахь асуудлыг шийдвэрлэхэд заавал явуулна:

6.1.1.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-т заасан асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлох;

6.1.2.орон нутгийг хөгжүүлэх сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ;

6.1.3.хот, суурин газрын хэсэгчилсэн төлөвлөлт /нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж/.

6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан асуудлаар зөвхөн Улсын Их Хурал, 6.1.2-т заасан асуудлаар бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, 6.1.3-т заасан асуудлаар Хот байгуулалтын тухай хуульд заасан эрх бүхий этгээд зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулах эрхтэй.



6.3.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд энэ хуулийн 6.1-д зааснаас бусад асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулж болно.

6.4.Нийтийн ашиг сонирхолд хамааралтай тодорхой асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулах талаар нийслэлийн хэмжээнд 500-аас дээш, дүүрэгт 300-аас дээш, аймагт 100-аас дээш, суманд 50-аас дээш тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч иргэний гаргасан санал, хүсэлтийг шийдвэр гаргах эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.

6.5.Зөвлөлдөх санал асуулгыг улсын хэмжээнд, эсхүл засаг захиргааны тодорхой нэгжийн хэмжээнд зохион байгуулна.

### **7 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулга явуулах шийдвэр гаргах**

7.1.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд зөвлөлдөх санал асуулга явуулах тухай шийдвэр гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан шийдвэрт дараахь асуудлыг тусгана:

- 7.2.1.зөвлөлдөх санал асуулгын сэдэв;
- 7.2.2.зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж явуулах хугацаа;
- 7.2.3.зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж явуулах нутаг дэвсгэр;
- 7.2.4.зөвлөлдөх санал асуулгын төсөв.

### **8 дугаар зүйл.Зөвлөлдөх зөвлөл, түүний чиг үүрэг**

8.1.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зөвлөлдөх санал асуулгыг олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх бүрэлдэхүүн бүхий Зөвлөлдөх зөвлөл удирдан зохион байгуулна.

8.2.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах тухай бүрд уг санал асуулгыг зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөлийг 5-11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

8.3.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн асуудлаар мэргэшсэн, хараат бус, мэдлэг, туршлага бүхий хорин нэгэн насанд хүрсэн Монгол Улсын иргэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн болон тухайн чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

8.4.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилохгүй.



8.5.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд тухайн зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх хугацааг товлон тогтоох бөгөөд уг хугацаа 7-оос доошгүй 14 хоногоос дээшгүй байна.

8.6.Энэ хуулийн 8.3-т заасан шаардлагыг хангасан эрдэмтэн, судлаачийг их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас, хувийн хэвшлийн төлөөллийг мэргэжлийн холбооноос, иргэнийг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас, эсхүл өөрөө нэр дэвшүүлэн санал болгоно.

8.7.Ирүүлсэн саналын дагуу нэр дэвшигчийн жагсаалт үйлдэж олон нийтэд мэдээлнэ.

8.8.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд энэ хуулийн 8.6-д заасан этгээдээс Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүний тоонд нийцүүлэн томилно.

8.9.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилохдоо эрх бүхий этгээд бүрэлдэхүүнийг сонгох болсон үндэслэл, шалтгааныг дурдаж олон нийтэд мэдээлнэ.

8.10.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд томилогдсон байнгын ажил эрхэлдэг иргэнд тухайн байгууллага цалинтай чөлөө олгоно.

8.11.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах ажил эрхэлдэггүй иргэнд урамшуулал олгож болох ба урамшууллын хэмжээг шийдвэр гаргах эрх бүхий этгээд зөвлөлдөх санал асуулгын төсөвт тусган тогтооно.

8.12.Зөвлөлдөх зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.12.1.зөвлөлдөх санал асуулгын асуултыг боловсруулах, хамрах хүрээ, тухайн зөвлөлдөх санал асуулгын үе шат бүрийн санал авах өдрийг тогтоох;

8.12.2.зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах;

8.12.3.зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд тухайн сэдвээр мэдээлэл өгөх судлаач, мэргэжилтэн, хөндлөнгийн шинжээч, төрийн байгууллага, албан тушаалтныг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд санал болгох;

8.12.4.зөвлөлдөх санал асуулгын дүнг хэлэлцэж, зөвлөмж гаргах;

8.12.5.зөвлөлдөх санал асуулгын талаархи мэдээллийг олон нийтэд хүргэх;



8.12.6.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих.

8.13.Зөвлөлдөх зөвлөл асуудлын хамрах хүрээ, ач холбогдлоос хамаарч шаардлагатай гэж үзвэл зөвлөлдөх санал асуулгын асуулт, зөвлөлдөх санал асуулга явуулах зохион байгуулалт, үйл явц энэ хуульд заасан зарчим, журмын дагуу явагдсан эсэх, маргаантай холбогдсон асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий техникийн хяналтын комиссыг ажиллуулж болно.

8.14.Энэ хуулийн 8.13-т заасан техникийн хяналтын комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Зөвлөлдөх зөвлөл батална.

8.15.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь Зөвлөлдөх зөвлөлийн ажлын албыг байгуулж, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **9 дүгээр зүйл.Зөвлөлдөх зөвлөлийн ажиллах журам**

9.1.Зөвлөлдөх зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

9.2.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүн дотроосоо нэр дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж даргыг сонгоно.

9.3.Зөвлөлдөх зөвлөлийн дарга хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг даргална.

9.4.Зөвлөлдөх зөвлөлийн хуралдаан нийт бүрэлдэхүүний дөрөвний гурав нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцогдож, хуралдаанд оролцсон бүрэлдэхүүний олонхийн саналаар шийдвэр гаргана.

9.5.Зөвлөлдөх зөвлөлийн шийдвэр нь зөвлөмж, санал байна.

9.6.Энэ хуулийн 8.15-д заасан ажлын алба нь хуралдааны бэлтгэл ажил, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах болон Зөвлөлдөх зөвлөлийн даргын даалгасан ажлыг гүйцэтгэнэ.

### **10 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах**

10.1.Зөвлөлдөх зөвлөл зөвлөлдөх санал асуулгын асуултыг батлах ба асуулт нь дараахь шаардлагыг хангасан байна:

10.1.1.нэг сэдвээр байх;

10.1.2.хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгомжтой томъёолсон байх;

### 10.1.3.гадаад үг хэрэглэхгүй байх.

10.2.Зөвлөлдөх санал асуулгын асуултыг батлахад шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн саналыг заавал авах бөгөөд мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн төлөөллийн саналыг авч болно.

10.3.Зөвлөлдөх санал асуулгаар санал авах ажлыг статистикийн байгууллага гүйцэтгэнэ.

10.4.Статистикийн байгууллага энэ хуулийн 10.3-т заасан ажлыг хөндлөнгийн, бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд түүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн<sup>3</sup> 33 дугаар зүйлд заасан журмын дагуу харьцуулалтын аргаар сонгон шалгаруулна.

10.5.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд энэ хуулийн 10.4-т заасны дагуу сонгон шалгаруулсан мэргэжлийн байгууллагатай Иргэний хуульд<sup>4</sup> заасны дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулна.

## **11 дүгээр зүйл.Зөвлөлдөх санал асуулгаар санал авах журам**

11.1.Зөвлөлдөх санал асуулгаар санал авах ажлыг энэ хуулийн 10.3-т заасан статистикийн байгууллага зохион байгуулж явуулна.

11.2.Зөвлөлдөх санал асуулга хоёр шаттай байна.

11.3.Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд иргэдэд зөвлөлдөх санал асуулгын сэдвээр урьдчилсан мэдлэг, мэдээлэл өгөхгүйгээр санал асуулгын хуудсаар саналыг нь авна.

11.4.Зөвлөлдөх санал асуулгын санал авах хуудас нь дараахь хэсгээс бүрдэнэ:

11.4.1.зөвлөлдөх санал асуулгад оролцогч иргэний талаархи хүн ам зүйн мэдээлэл;

11.4.2.зөвлөлдөх санал асуулгын үндсэн асуулт;

11.4.3.асуулт нэг бүрээр санал тэмдэглэх хэсэг.

11.5.Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд Монгол Улсын арван найман насанд хүрсэн иргэн оролцох эрхтэй бөгөөд оролцох иргэний тоог зөвлөлдөх санал асуулгын сэдэв, хамрах хүрээг харгалзан Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлалын дагуу Зөвлөлдөх зөвлөл тогтооно.

<sup>3</sup>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Иргэний хууль «Төрийн мэдээлэл» эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.



11.6.Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд оролцох иргэнийг энэ хуулийн 11.5-д заасан тоонд багтаан хамгийн сүүлийн удаа явагдсан Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулиар гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтаас тохиолдлын зарчмаар сонгож авна.

11.7.Энэ хуулийн 11.6-д заасны дагуу сонгогдсон иргэн тухайн санал асуулгад оролцохоос татгалзах эрхтэй бөгөөд ийнхүү татгалзсан тохиолдолд дараагийн хүнийг энэ хуулийн 11.6-д заасан журмаар дахин сонгож авна.

11.8.Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд нэг дэх шатанд оролцсон иргэний 50-аас доошгүй хувийг тохиолдлын зарчмаар сонгон авна.

11.9.Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд шийдвэр гаргах эрх бүхий этгээд санал авах ажлыг зөвлөлдөх уулзалт хэлбэрээр зохион байгуулах бөгөөд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах журмыг тогтооно.

11.10.Энэ хуулийн 11.9-д заасан журамд дараахь зүйлийг заавал тусгана:

11.10.1.зөвлөлдөх санал асуулгын асуулт тус бүрээр эерэг, сөрөг мэдээллийг тэгш агуулсан лавлагаа, танилцуулгыг бэлтгэх;

11.10.2.зөвлөлдөх санал асуулгад оролцогчид олгох урамшуулал, томилолтын зардал /байр, хоол, унаа/-ыг төлөх;

11.10.3.хоёр дахь шатны зөвлөлдөх санал асуулга буюу зөвлөлдөх уулзалтад оролцогчийг 15-аас илүүгүй хүнтэй хэсэг болгож, бүрэлдэхүүнийг тохиолдлын зарчмаар сонгох;

11.10.4.хэсэг бүрд явагдах хэлэлцүүлгийг хөтлөх бэлтгэгдсэн хөтлөгч /модератор/ нь тухайн хэсгийн оролцогчид мэдээллийг бүрэн хүргэж, оролцогчийн тэгш оролцоог хангах үүргийг хариуцах;

11.10.5.хэсэгт явагдах хэлэлцүүлгийн бүх ажиллагааг дууны болон дүрсний бичлэгээр баталгаажуулах;

11.10.6.хэсэгт явагдсан хэлэлцүүлэгт оролцогчийн асуултыг нэгтгэн зөвлөлдөх уулзалтын нийт оролцогчид тухайн санал асуулгын сэдвээр олон талт мэдээлэл, тайлбар, танилцуулгыг шийдвэр гаргах эрх бүхий этгээд, хөндлөнгийн судлаач, мэргэжилтэн, шинжээч өгөх.

11.11.Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд санал авах ажлыг гүйцэтгэх статистикийн байгууллага нь нэг дэх шатны санал



асуулгын хуудсаар саналыг нь дахин авна. Энэ хуулийн 11.4.3-т заасан зөвлөлдөх санал асуулгын санал авах хуудас дахь мэдээлэл нууц байна.

11.12.Зөвлөлдөх санал асуулгын хамрах хүрээ, сэдвээс хамааран нэг дэх шатыг алгасан хоёр дахь шатыг зохион байгуулж болно.

11.13.Энэ хуулийн 11.12-т заасны дагуу зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах шийдвэрийг Зөвлөлдөх зөвлөлтэй зөвшилцөх буюу санал нэгдсэний үндсэн дээр шийдвэр гаргах эрх бүхий этгээд гаргана.

11.14.Зөвлөлдөх санал асуулгад оролцогч иргэн саналаа чөлөөтэй гаргахад хөндлөнгөөс нөлөөлөх, санал худалдан авахыг хориглоно.

11.15.Энэ хуулийн 11.10.4-д заасан хөтлөгч өөрийн байр сууриа илэрхийлэх, өөр мэдээлэл өгөх зэргээр хэлэлцүүлэгт оролцож бусдад нөлөөлөхийг хориглоно.

## **12 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулгын дүнг нэгтгэн зөвлөмж гаргах**

12.1.Энэ хуулийн 10.3-т заасан статистикийн байгууллага зөвлөлдөх санал асуулгын нэг дэх болон хоёр дахь шатны дүнг тоон болон бусад үзүүлэлтээр харьцуулан гаргасан дүгнэлтийг зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн тайланд тусгаж Зөвлөлдөх зөвлөлд танилцуулна.

12.2.Зөвлөлдөх санал асуулгын дүнг Зөвлөлдөх зөвлөл хэлэлцэн зөвлөмж гаргаж, шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

12.3.Зөвлөлдөх санал асуулгын үйл явц олон нийтэд ил тод, нээлттэй байна.

12.4.Зөвлөлдөх санал асуулгын дүнд үндэслэсэн зөвлөмжийг шийдвэр гаргах эрх бүхий этгээд харгалзан үзэх бөгөөд хэрхэн шийдвэрлэсэн талаархи мэдээллийг Зөвлөлдөх зөвлөл болон олон нийтэд өгнө.

## **13 дугаар зүйл.Зөвлөлдөх санал асуулгын санхүүжилт**

13.1.Зөвлөлдөх санал асуулга явуулахтай холбогдсон зардлыг доор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

13.1.1.улсын төсөв;

13.1.2.орон нутгийн төсөв.



**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ****14 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

14.1.Энэ хуулийн 5.2, 11.14-т заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА****М.ЭНХБОЛД****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалт:**

“5.3.3.Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хорьдугаар зүйл, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг явуулах;”

**2/5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалт:**

“5.3.4.Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6.1.1-д заасны дагуу явуулсан санал асуулгын дүнгээр энэ хуулийн 5.3.3-т заасан асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн бол Улсын Их Хурал заавал авч хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах.”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “Тавдугаар зүйлийн 1-4 дэх хэсэг” гэснийг “Тавдугаар зүйлийн 1-3 дахь хэсэг” гэж, “Дөчин нэг” гэснийг “Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын



“Хорьдугаар зүйл,” “Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН  
АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсгийн “Сонгуулийн” гэснийг “Зөвлөлдөх санал асуулга болон сонгуулийн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “сумын мэргэн” гэсний дараа “, хоёрдугаар байр эзэлсэн харваачид аймаг, сумын гарамгай харваач, гуравдугаар байр эзэлсэн харваачид аймаг, сумын гоц харваач” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“9.2.Улсын баяр наадмын үндэсний сурын харваанд гуравдугаар байр эзэлсэн харваачид улсын гоц харваач, хоёрдугаар байр эзэлсэн харваачид улсын гарамгай харваач, нэг түрүүлсэн харваачид улсын мэргэн, улсын мэргэн цолтон түрүүлбэл улсын даян мэргэн, улсын даян мэргэн цолтон түрүүлбэл улсын даяар дуурсах мэргэн, улсын даяар дуурсах мэргэн цолтон түрүүлбэл улсын дархан мэргэн цол олгоно.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнөх жилүүдийн улсын баяр наадмын үндэсний сурын харваанд оролцож, тухайн хуульд заасан цолны болзлыг хангасан харваачид цолыг нөхөн олгоно.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН  
БАНКНЫ ТУХАЙ**

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.**Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Хөгжлийн банк” гэх)-ны үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион

байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож зохицуулахад оршино.

## **2 дугаар зүйл.Хөгжлийн банкны хууль тогтоомж**

2.1.Хөгжлийн банкны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар, энэ хуульд өөрөөр заагаагүй бол бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

## **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” гэж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн<sup>2</sup> 4.1.7-д заасныг;

4.1.2.“дунд хугацааны хөгжлийн бодлого” гэж Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан баримт бичгийг.

## **5 дугаар зүйл.Хөгжлийн банкны эрх зүйн байдал**

5.1.Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна.

5.2.Хөгжлийн банкийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргана.

## **6 дугаар зүйл.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө**

6.1.Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг хувьцаа эзэмшигч тогтооно.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 47 дугаарт нийтлэгдсэн.



6.2.Хөгжлийн банк нь тухайн жилийн цэвэр ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үлдэх хэсгээр алдагдлыг нөхөх зорилго бүхий нөөц сан байгуулна.

6.3.Хөгжлийн банкны алдагдлыг нөөц сангийн хөрөнгөөр нөхөх боломжгүй тохиолдолд нэмэлт хөрөнгө олгох эсэхийг хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ.

6.4.Энэ хуулийн 6.2-т заасан санг бүрдүүлэх, түүнийг удирдах журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

### **7 дугаар зүйл.Хөгжлийн банкны баримтлах зарчим**

7.1.Хөгжлийн банк нь үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалын дараахь зарчмыг баримтална:

7.1.1.ашигтай ажиллах;  
7.1.2.үйл ажиллагаагаа тогтвортой явуулах;  
7.1.3.хараат бус байх;  
7.1.4.ил тод байх;  
7.1.5.хариуцлагатай байх;  
7.1.6.Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр нь хамтын удирдлагад үндэслэсэн байх;

7.1.7.хараат бус хөндлөнгийн хяналттай байх.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан зарчмыг энэ хууль, түүнд нийцүүлэн баталсан дүрэм, журамд тусган хэрэгжүүлнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **8 дугаар зүйл.Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ**

8.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

8.1.1.төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх;  
8.1.2.төлбөр тооцоо хийх;  
8.1.3.баталгаа, батлан даалт гаргах;  
8.1.4.үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах;

8.1.5.зээл авах;  
8.1.6.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах;  
8.1.7.компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх;

8.1.8.төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

8.1.9.экспорт, импортын санхүүжилт хийх;

8.1.10.төлбөрийн чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх.

8.2.Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах нийт санхүүжилтийн дүнгийн 60-аас доошгүй хувийг экспортыг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулна.

8.3.Хөгжлийн банк нь иргэдийн мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

## **9 дүгээр зүйл.Зээл авах**

9.1.Хөгжлийн банк энэ хуулийн 25.1-д заасан үзүүлэлт, журам, 28 дугаар зүйлд заасан хязгаарлалтад нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зээл авч болно.

## **10 дугаар зүйл.Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх**

10.1.Хөгжлийн банк дараахь шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ:

10.1.1.Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх;

10.1.2.эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх;

10.1.3.техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх;

10.1.4.эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжих, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх;

10.1.5.төслийн эрсдэлийн үнэлгээ, санхүүжилт авах үндэслэл, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөөг мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх;

10.1.6.энэ хуулийн 8.1.7-д зааснаас бусад санхүүжилт нь Засгийн газрын өрийн баталгаа, барьцаа, баталгаа зэрэг үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслээр хангагдсан байх.

10.2.Хөгжлийн банк энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлнэ.



10.3.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад нөхцөл, шаардлагыг Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл тодорхойлно.

10.4.Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх шийдвэрийг Хөгжлийн банк гаргах ба шийдвэр гаргахтай холбоотой журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

### **11 дүгээр зүйл.Төлбөр тооцоо хийх**

11.1.Хөгжлийн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд<sup>3</sup> заасны дагуу зохицуулна.

11.2.Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг Хөгжлийн банк тогтооно.

### **12 дугаар зүйл.Баталгаа, батлан даалт гаргах**

12.1.Хөгжлийн банк нь энэ хуулийн 25.1-д заасан үзүүлэлт, журам, 28 дугаар зүйлд заасан хязгаарлалтад нийцүүлэн дангаар болон бусад этгээдтэй хамтран гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргаж болно.

12.2.Баталгаа, батлан даалтыг энэ хуулийн 10.1.2-10.1.5-д заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрт гаргаж болно.

### **13 дугаар зүйл.Үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах**

13.1.Хөгжлийн банк нь энэ хуулийн 25.1-д заасан үзүүлэлт, журам, 28 дугаар зүйлд заасан хязгаарлалтад нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр үнэт цаас гаргаж болно.

13.2.Хөгжлийн банкны санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

### **14 дүгээр зүйл.Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах**

14.1.Хөгжлийн банкны гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

<sup>3</sup>Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



### **15 дугаар зүйл.Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх**

15.1.Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө байршуулах шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газар гаргана.

### **16 дугаар зүйл.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх**

16.1.Хөгжлийн банк төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлж болно.

### **17 дугаар зүйл.Экспорт, импортын санхүүжилт хийх**

17.1.Экспорт, импортын санхүүжилт хийх төсөл, хөтөлбөр нь энэ хуулийн 10.1-д заасан шаардлагыг хангасан байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БАНКНЫ УДИРДЛАГА**

### **18 дугаар зүйл.Хөгжлийн банкны удирдлага**

18.1.Хөгжлийн банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний чөлөөт цагт төлөөлөн удирдах зөвлөл байна.

18.2.Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч нь Засгийн газар, Хөгжлийн банкинд хувь нийлүүлсэн бусад этгээд байна.

### **19 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл**

19.1.Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн дөрөв нь хараат бус гишүүн байна.

19.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон гурван жилийн хугацаагаар томилж, Компанийн тухай хуульд<sup>4</sup> заасан үндэслэлээр чөлөөлнө. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

19.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар томилно.

19.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 50-аас дээш хувийг тухайн төсвийн жилийн хугацаанд өөрчлөхийг хориглоно.

<sup>4</sup>Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.





19.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь дараахь шалгуурыг хангасан байна:

19.5.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

19.5.2.банк, санхүү, хууль, инженер, эдийн засгийн дээд боловсролтой, уг салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;

19.5.3.ял шийтгэлгүй байх;

19.5.4.төрийн улс төрийн албан тушаал хашдаггүй байх;

19.5.5.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;

19.5.6.банкны салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан бус байх;

19.5.7.зөрчлийн улмаас банк, банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;

19.5.8.санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ захиргааны хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.

19.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь энэ хуулийн 19.5, Компанийн тухай хуулийн 79.1-д зааснаас гадна дараахь шалгуурыг хангасан байна.

19.6.1.төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх, сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал хашиж байгаагүй;

19.6.2.банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд бус байх;

19.6.3.банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшдэггүй байх.

## **20 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

20.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:



20.1.1.Хөгжлийн банкны дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан батлах;

20.1.2.Хөгжлийн банкны тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлах;

20.1.3.үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;

20.1.4.Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах журам батлах, түүнтэй гэрээ байгуулах, дүгнэх;

20.1.5.Хөгжлийн банкны зохион байгуулалтын бүтэц, жилийн төсөв, орон тооны дээд хязгаарыг батлах;

20.1.6.Хөгжлийн банкны зээлийн, хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, актив, пассивын удирдлагын бодлогыг батлах;

20.1.7.энэ хуулийн 25.1-д заасан үзүүлэлт, журмын төсөлд санал хүргүүлэх;

20.1.8.хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын санал хүргүүлэх;

20.1.9.энэ хуулийн 25.1-д заасан журам, 28.1-д заасан хязгаарлалтыг мөрдөж ажиллах;

20.1.10.хувьцаа эзэмшигчид жил бүр ажлаа тайлагнах;

20.1.11.Хөгжлийн банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэх;

20.1.12.банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, ажилтныг томилох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

20.1.13.аудитын байгууллагыг сонгох.

20.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэгт Компанийн тухай хуулийн 76.1.2, 76.1.3-т заасан эрх, үүрэг хамаарахгүй.

20.3.Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл сард нэгээс доошгүй удаа хуралдана.

20.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэйгээр хуралдааныг хуралдуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.



20.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд гаргасан саналынхаа төлөө Компанийн тухай хуулийн 84.8, 84.9, 85 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

20.6.Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтооно.

### **21 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх**

21.1. Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

21.2. Гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

21.3. Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, газрын захирлуудыг энэ хуулийн 20.1.4-т заасан журмын дагуу олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, чөлөөлнө.

21.4. Гүйцэтгэх захирал нь дараахь шаардлагыг хангасан байна:

21.4.1. банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, санхүүгийн салбарт удирдах албан тушаалд таваас доошгүй жил ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;

21.4.2. ял шийтгэлгүй, ёс зүй болон бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй байх;

21.4.3. төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон бусад шаардлага.

21.5. Гүйцэтгэх удирдлага Компанийн тухай хуульд зааснаас гадна дараахь эрхийг хэрэгжүүлнэ:

21.5.1. хуульд төлөөлөн удирдах зөвлөл батлахаар зааснаас бусад Хөгжлийн банкны дотоод дүрэм, журам, заавар, аргачлал болон хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлийг батлах;

21.5.2. санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой санхүү бүртгэл, мэдээлэл, удирдлага, зохион байгуулалтын асуудлаар шийдвэр гаргах;

21.5.3. Хөгжлийн банкны жилийн төсвийг боловсруулан батлуулж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэлийг тайлагнах;

21.5.4. шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх;

21.5.5. төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд Хөгжлийн банкныг төлөөлөх, гэрээ, хэлцэл байгуулах;

21.5.6.хүний нөөцийн бодлого, цалингийн сүлжээ батлах, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, түүнд олгох урамшуулал, хөнгөлөлт, тусламж, тэтгэмжийн хэмжээг тогтоох, сахилгын шийтгэл ногдуулах;

21.5.7.Хөгжлийн банкны нэрийн өмнөөс холбогдох мэдээ, тайланг харилцагчаас шаардан авах, тэдний тайлан тэнцэлтэй танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаалах, санхүүжилтийг түр зогсоох;

21.6.Гүйцэтгэх удирдлага дараахь үүрэг хүлээнэ:

21.6.1.Хөгжлийн банкны үйл ажиллагааны дунд, урт хугацааны стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

21.6.2.энэ хуулийн 25.1-д заасан журам, 28.1-д заасан хязгаарлалтыг мөрдөж ажиллах;

21.6.3.санхүүгийн сахилга батыг сахиулах, Хөгжлийн банкны хэвийн үйл ажиллагааг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

21.6.4.банкны дотоод нэгжүүд болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанийн үйл ажиллагааны уялдааг хангах;

21.6.5.хөрөнгө оруулах төсөл, хөтөлбөрийн болон зээлийн шинжилгээ, үнэлгээ хийх зориулалтаар мэдээллийн сан бүрдүүлэх;

21.6.6.зээлийн болон дотоод хяналт, шалгалтын тогтолцоо бүрдүүлэх;

21.6.7.Хөгжлийн банкны өмнө хүлээсэн бусад этгээдийн үүргийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

21.6.8.үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах;

21.6.9.хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, эх үүсвэрийн чөлөөт үлдэгдлийг зах зээлд хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэлд үр өгөөжтэй байршуулах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

21.6.10.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, зээлийн талаархи мэдээллийг цаг тухайд нь гаргаж, тэдгээрийн үнэн зөв байдлыг хариуцах;

21.6.11.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, олгосон зээлийн хэмжээ, гаргасан үнэт цаас, түүний



борлуулалтын хэмжээ, эх үүсвэр татан төвлөрүүлэлт, үр ашгийн байдал, цаашдын төлөв хандлагын талаар санал боловсруулан төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

21.6.12.Хөгжлийн банкны санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

21.6.13.хувийн ашиг сонирхолтой нь холбогдсон асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцохгүй байх;

21.6.14.төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө ажлаа улирал бүр тайлагнах;

21.6.15.энэ хуулийн 8.1.7-д заасан болон Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч этгээдийн эрх бүхий албан тушаалтнаар томилогдохоос бусад тохиолдолд өөр байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхгүй байх;

21.6.16.энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан Хөгжлийн банкны мэдээллийг нийтэд тайлагнах явцад хяналт тавих.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

### **22 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

22.1.Монгол Улсын Их Хурал Хөгжлийн банкны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.Хөгжлийн банкиг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэртэй танилцах;

22.1.2.Хөгжлийн банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцах.

22.2.Улсын Их Хурал Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төслийн жагсаалтыг тусгайлан батлахгүй.

### **23 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

23.1.Засгийн газар Хөгжлийн банкны талаар Компанийн тухай хуулийн 62.1-д заасан хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



23.1.1.Хөгжлийн банкны буцаан худалдан авах нөхцөлтэй гаргасан урт хугацаат үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх;

23.1.2.Хөгжлийн банкны санхүүгийн тайлангийн талаархи аудитын дүгнэлтийг баталж, түүний үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтийн хамт Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх;

23.1.3.Хөгжлийн банкны санхүү, төлбөрийн чадварын хэвийн, тогтвортой байдлыг хангах цогц арга хэмжээ авах;

23.1.4.Хөгжлийн банкны дүрмийг батлах;

23.1.5.Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

23.1.6.Хөгжлийн банкны үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хоёр жил тутамд ээлжит хяналт, шалгалт хийх ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хяналт, шалгалт хийх;

23.1.7.Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг батлах;

23.1.8.Засгийн газраас Хөгжлийн банкинд баталгаа гаргаж болох ба уг харилцааг Өрийн удирдлагын тухай хуульд<sup>5</sup> заасны дагуу зохицуулна.

23.2.Засгийн газар Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй.

#### **24 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

24.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн банкны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.Хөгжлийн банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах талаар санал боловсруулж Засгийн газарт хүргүүлэх;

24.1.2.энэ хуулийн 5.1-д заасан чиг үүргийн хэрэгжилтийн хүрээнд шаардлагатай мэдээллийг Хөгжлийн банкнаас гаргуулан авах;

24.1.3.Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр дамжуулан Засгийн газарт хүргэх.

<sup>5</sup>Өрийн удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 09 дугаарт нийтлэгдсэн.



**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО,**  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ**

**25 дугаар зүйл.Хөгжлийн банканд тавих хяналт**

25.1.Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Монголбанк батална.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан журам, 28.1-д заасан хязгаарлалтыг Хөгжлийн банк хэрхэн мөрдөж байгаад Монголбанк хяналт тавьж, шалгалт хийнэ.

25.3.Засгийн газар энэ хуулийн 23.1.6-д заасны дагуу хяналт, шалгалт хийнэ.

25.4.Энэ хуулийн 25.3-т заасан хяналт, шалгалт хийх журмыг Засгийн газар батална.

**26 дугаар зүйл.Хөгжлийн банкны дотоод аудит**

26.1.Хөгжлийн банк нь төлөөлөн удирдах зөвлөлийн шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах дотоод аудитын нэгжтэй байна.

26.2.Хөгжлийн банкны дотоод аудитын нэгж нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан банкны бодлого, төлөвлөгөө, төсөв болон бусад шийдвэрийн хэрэгжилт, дотоод хяналтын үйл ажиллагаанд аудит хийж, зөвлөмж өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.3.Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

**27 дугаар зүйл.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт**

27.1.Хөгжлийн банк хянан шалгагчтай байх бөгөөд хянан шалгагч нь энэ хууль болон гэрээний дагуу тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ.

27.2.Хянан шалгагч дараахь эрхтэй байна:

27.2.1.төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн данс бүртгэл, тайлан тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа болон шаардлагатай бусад материалыг гаргуулан авах;

27.2.2.төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж явцын тайлан, холбогдох саналаа Хөгжлийн банкны удирдлагад танилцуулах;

27.2.3.хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг холбогдох эрх бүхий улсын байцаагчид тавьж шийдвэрлүүлэх.

27.3.Хянан шалгагчийн бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг энэ хуульд нийцүүлэн Хөгжлийн банкны дүрмээр тогтооно.

### **28 дугаар зүйл.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт**

28.1.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд дараахь хязгаарлалт тавигдана:

28.1.1.зээл, баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийг 30 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй бөгөөд түүний хэмжээг Монголбанк тогтооно.

28.1.2.Монголбанк нь том зээлдэгчийг тодорхойлох, түүнд олгох зээлийн дээд хэмжээ болон нийт хэмжээг тогтоох, тайлагнах журмыг батална. Нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээлийн нийт хэмжээ нь Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг 8 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байна.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ**

#### **29 дүгээр зүйл.Санхүүгийн тайлагнал**

29.1.Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ.

29.2.Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлага хариуцна.

29.3.Хөгжлийн банк нь холбогдох тайлан, мэдээллийг Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан тайлан, мэдээлэл гаргах журам, загвар, маягтыг Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

#### **30 дугаар зүйл.Ил тод байдал**

30.1.Хөгжлийн банкны жилийн эцсийн аудит хийсэн санхүүгийн тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.





30.2.Хөгжлийн банк шаардлагатай мэдээллийг хуульд заасны дагуу гаргаж өгнө.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **31 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

31.1.Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч, эсхүл холбогдох улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

31.1.1.энэ хуулийн 10.1-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.2.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хяналт шалгалтад саад учруулсан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.3.төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан ажилтан, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.4.тайлан тэнцэл, мэдээ баримтыг зохих хууль, журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлээгүй, нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.5.нийтлүүлсэн тайлан, мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол уг тайлан, мэдээллийг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, эрх бүхий бусад албан тушаалтныг тус бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас хоёр зуун хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.6.энэ хуулийн 8.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.



**32 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох**

32.1. Энэ хуулийг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ  
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг хүчингүйд болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“2<sup>1</sup> дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Банкны тухай хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийн 2<sup>1.1</sup> дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2<sup>1.1</sup>.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд тусгайлан зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Нийтийн сонсгол зохион байгуулах журам батлах тухай

Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2017 оны  
12 дугаар тогтоолын хавсралт

## НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.Энэ журмын зорилт нь ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах үндэслэл, нарийвчилсан журам, сонсголын дэгийг тогтооход оршино.

2.Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага Нийтийн сонсголын тухай хуулийн 8.3, 9.3-т заасан

ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулахдаа энэ журмыг баримтална.

### **Хоёр.Нийтийн сонсгол зохион байгуулах үндэслэл**

1.Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд хүсэлтэд сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх ба сэдэв, зорилго, товын талаархи саналаа тусгаж болно.

2.Хүсэлтийн дагуу сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг зохион байгуулагч, түүний ажлын алба хянан үзээд зохион байгуулах нь зүйтэй гэж үзвэл хариу мэдэгдэн сонсголд бэлтгэнэ.

3.Иргэн, хуулийн этгээд ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ирүүлсэн бол хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Нийтийн сонсголын тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тухайн асуудлаар сонсгол зохион байгуулах эсэхийг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв сонсгол зохион байгуулах шаардлагагүй гэж үзсэн бол үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын гурван өдөрт багтаан бичгээр өгнө.

4.Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага төсвийн хяналтын сонсголыг жилд нэг удаа өөрийн эрхлэх асуудал, хамаарах төсвийн хүрээнд зохион байгуулна.

5.Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах хугацааг товлон зарламагц тухайн асуудлаар төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар холбогдох баримт бичгийг хүргүүлнэ. Төрийн аудитын байгууллага гаргасан дүгнэлтээ сонсгол зохион байгуулахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө ирүүлнэ.

6.Ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах тов, сэдэв, сонсгол даргалагчийг томилох асуудлыг Засгийн газар хуралдаанаараа, төрийн захиргааны төв байгууллагын хувьд сайд, нутгийн өөрөө удирдах байгууллагын хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, нутгийн захиргааны байгууллагын хувьд Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.

7.Сонсгол даргалагчийг томилохдоо сонсгол зохион байгуулах сэдвийг харгалзан тухайн асуудлаар мэргэшсэн, эсхүл туршлагатай, ашиг сонирхлын зөрчилгүй албан тушаалтныг сонгоно.

### **Гурав.Нийтийн сонсголын бэлтгэл хангах**

1.Сонсгол зохион байгуулагчаас сонсголын товыг тогтоосон бол товлосон өдрөөс хойш долоо хоногийн дотор Нийтийн сонсголын тухай



хуулийн 21 дүгээр зүйлд заасан арга хэрэгслээр сонсгол явуулах огноо, цаг, сэдэв, байр, ажиглагчаар оролцох хүний тоо, оролцогчдыг хэрхэн бүртгэх, бүртгэл дуусах хугацааны талаар нийтэд мэдээлнэ.

2. Сонсголын товгыг хойшлуулсан бол Нийтийн сонсголын тухай хуулийн 20.4-д зааснаар дахин зарлана.

3. Сонсгол зохион байгуулах танхимыг бэлтгэх, техникийн бэлтгэлийг хангах, сонсголын тэмдэглэл хөтлөх, сонсгол даргалагчийн даалгаснаар сонсголын дэг зөрчигчийг танхимаас гаргах, сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг урьж оролцуулах ажлыг Нийтийн сонсголын тухайн хуулийн 16.1-д заасан этгээд /цаашид “ажлын алба” гэх/ хариуцна.

4. Хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулахдаа урилгыг олон нийтэд мэдээлэх ба хэвлэл мэдээллийн байгууллага төлөөллөө оролцуулах хүсэлтээ сонсгол зохион байгуулахаас ажлын зургаагаас доошгүй өдрийн өмнө бичгээр ирүүлнэ.

5. Сонсголд оролцогч, ажиглагч, шинжээч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийн тооны дээд хязгаарыг сонсгол болох танхимын багтаамж, тухайн асуудлын хүрээнээс хамааран сонсгол зохион байгуулагч тогтооно.

6. Тухайн сонсголд оролцож санал хэлэх, тайлбар, мэдээлэл өгөх, эсхүл ажиглах иргэн, хуулийн этгээд нь сонсгол болохоос ажлын арваас доошгүй өдрийн өмнө сонсгол зохион байгуулагчид мэдэгдэж, оролцогч, эсхүл ажиглагчаар оролцохоо бүртгүүлнэ. Шаардлагатай бол санал, тайлбар, мэдээллээ урьдчилан бичгээр ирүүлэх ба ажлын алба оролцогчид хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, сонсголд оролцох зааварчилгаа өгнө.

7. Бүртгүүлэхдээ бичгээр, харилцах утсаар, эсхүл зохион байгуулагч байгууллагын цахим шууданд захидал илгээн бүртгүүлж болох ба бүртгэлийг ажлын алба хянан үзээд оролцогчийн тооны дээд хязгаараас хамаарч бүртгүүлсэн цаг хугацааны дарааллаар нь бүртгэлийг баталгаажуулна.

8. Сонсгол зохион байгуулагч шаардлагатай гэж үзвэл шинжээч томилж, сонсголд оролцуулж болох бөгөөд шинжээчийн үйл ажиллагааны зардлыг сонсгол зохион байгуулах байгууллагын төсвөөс гаргана.

9. Ажлын алба энэ журмын 3.4, 3.6, 3.7-д заасны дагуу бүртгэсэн нэрсийг сонсгол даргалагчид хэлэлцүүлэг эхлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө танилцуулж, сонсгол даргалагчийн урилгаар оролцох хүмүүсийн нэрсийг авна. Бүртгүүлсэн болон урилгаар оролцох оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийн нэрсийг бүртгүүлсэн

дарааллын дагуу холбогдох байгууллагын цахим хуудсанд хэлэлцүүлэг эхлэхээс гурваас доошгүй хоногийн өмнө байршуулна.

10.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг сонсгол даргалагчийн урилгаар оролцуулна.

11.Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг урьж оролцуулахдаа сонсгол хийх сэдэв, асуудлаар мэргэшсэн байгууллагуудын нэгдэл буюу холбоодоос албан бичгээр санал авна. Саналд сонсголын сэдэв, тов болон төлөөллийн тоог тусгана. Ирүүлсэн саналтай нь холбогдуулан зохион байгуулагч урилга явуулан тухайн холбоо, байгууллагын төлөөллийг сонсголд заавал оролцох нөхцөлөөр хангана.

12.Сонсголд заавал оролцож, тодорхой асуудлаар тайлбар, мэдээлэл хийх төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч нарт сонсгол болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө сонсголд оролцох талаар мэдэгдэх бөгөөд тэдний нэрсийг нийтэд мэдээлнэ.

13.Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд заавал оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч сонсголд оролцох, мэдээлэл, тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 15.1.16-д заасан нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох журмыг зөрчсөн гэж үзнэ.

### **Дөрөв.Нийтийн сонсгол зохион байгуулах**

1.Сонсгол даргалагч сонсголын сэдэв, хүсэлт, сонсгол зарласан огноо, сонсголд дуудагдсан албан тушаалтан, холбогдох этгээд, шинжээч, тайлбар хийх хүний нэр, сонсголд оролцогчдын тоо, сонсголын дэг зэргийг 10 минутад багтаан танилцуулна.

2.Сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасан этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч хүсэлтийнхээ үндэслэл, шаардлагын талаар 10 минутад багтаан танилцуулна.

3.Сонсголд оролцогч санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах дарааллыг сонсгол даргалагч тогтоох ба оролцогчид сонсголын танхимд ирсэн хугацааны дагуу санал хэлэх эрхийг олгож болно. Дарааллыг тогтоохдоо эерэг болон эсрэг саналтай, олонхи болон цөөнхийн төлөөллийг оролцуулах зарчим баримтална.

4.Ажиглагч нь сонсголын үед асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.

5.Сонсголд оролцогчийн үг хэлэх хугацааг 3-10 минутаар тогтооно.



6.Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгоно.

7.Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл сонголд оролцохдоо бусад оролцогчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

8.Санал, тайлбар, дүгнэлттэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.

9.Асуулт, хариулт дууссаны дараа сонголд оролцогчид болон хүсэлт гаргасан төлөөлөл санал, дүгнэлтээ оролцогчдын тооноос хамааран 1-3 минутын хугацаанд хэлнэ.

10.Асуулт асуух, үг хэлэхдээ сонсголын сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сонсгол даргалагч асуулт асуух, үг хэлэхийг хязгаарлаж болно.

11.Сонголд оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, бусдын яриаг таслах, зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хашгирах, шүгэлдэх зэргээр бусдад үгээ чөлөөтэй хэлэхэд саад учруулсан болон сонсгол зохион байгуулагч, сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзвал сонсгол даргалагч дэг баримтлахыг шаардаж, шаардлагыг үл биелүүлбэл ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.

12.Сонсгол даргалагч сонсголыг хааж үг хэлнэ.

13.Ажлын алба сонсголын тэмдэглэлийг аудио болон бичгэн /товч/ хэлбэрээр хийж тухайн байгууллагын албан ёсны цахим хуудсанд ажлын таван өдрийн дотор байршуулна.

14.Сонсгол дууссаны дараа сонсголын үйл ажиллагаа болон сонсголын үед хэлэлцэгдсэн асуудал, асуулт, хариулт, мэдээлэл, дүгнэлт зэрэгтэй холбогдуулан ямар нэгэн зарга, гомдол үүсгэхгүй ба ямар нэгэн арга хэмжээ авагдахгүй.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 01 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14



дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нархүүгийн Тулгыг эгүүлэн татаж, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Санжаагийн Баярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2017 оны 01 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригийн Алтайг эгүүлэн татаж, Шведийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мэндсайханы Энхсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2017 оны 01 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадамдоржийн Батхишигийг эгүүлэн татаж,





Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Равдангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2017 оны 01 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Европын Холбооны дэргэд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хишигдэлгэрийн Даваадоржийг эгүүлэн татаж, Европын Холбооны дэргэд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Одын Очийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

#### **Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

**Индекс: 200003**